



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.01.10 № 01/22  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА НАРТ

### Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаар олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбоотой дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ыг хэрэгжүүлэх талаар:

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5, 1.5, 2.5 хувь, ажил олгогчийн төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5 хувь байхаар тус тус өөрчилсөн. Тэтгэврийн (8.5, 8.5), тэтгэмжийн (1.0, 0.8), эрүүл мэндийн (2.0, 2.0) даатгалын ажил олгогч, даатгуулагчийн, ажилгүйдлийн даатгалын даатгуулагчийн (0.2) төлөх хувь хэмжээ өөрчлөгдөөгүй тул хэвээр мөрдөнө.

Иймд нийгмийн даатгалын бүх төрөлд ажил олгогч эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлого (цаашид “цалин хөлс” гэх)-оос 12.5, 13.5, 14.5 хувиар, даатгуулагч 11.5 хувиар, нийт дүнгээр 24.0, 25.0, 26.0 хувиар тооцон шимтгэл ногдуулан төлүүлэх зохицуулалтыг хэвээр мөрдөнө.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар баталсан эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн төлбөл зохих үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5, 2.5 хувиар төлөх жагсаалтыг баримтлан ажил олгогчийн шимтгэл төлөлтийн 2024 оны 01 дүгээр сарын тайланг хүлээн авах бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.

1.2. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 3929 төгрөг, сард 660 000 (зургаан зуун жаран мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

1524670138

Иймд албан журмаар даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээ 6 600 000 ( $660\,000 \cdot 10$ ) төгрөг, сард төлөх шимтгэлийн дээд хэмжээ нь 759 000 ( $6\,600\,000 \cdot 11.5\%$ ) төгрөг байна.

1.3. “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код”-ын жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7, 21 дүгээр зүйлд тус тус заасныг баримтлан шинэчлэн боловсруулж Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар хүргүүлээд байна. Энэхүү тушаалаар баталсан даатгуулагчийн төрөл, кодын жагсаалтыг баримтлан ажил олгогчийн шимтгэл төлөлтийн 2024 оны 01 дүгээр сарын тайланг хүлээн авахаар бэлтгэж байна.

1.4. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд шимтгэл ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ” гэж заасан.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд шимтгэл ногдох цалин хөлсний хэмжээг Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор баталсан итгэлцүүрээр өсгөн, тухайн цалин хөлсийг олгосон хугацаанд мөрдсөн ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон нөхөн төлүүлэх шимтгэлийн хэмжээг тогтооно.

Албан журмын даатгуулагчийн шимтгэл нөхөн ногдуулах итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь Засгийн газрын дээр дурдсан тогтоолын дагуу 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 404 000 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөг, мөн өдрөөс хойших хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Ажил олгогчийн шимтгэл нөхөн ногдуулах итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээг хязгаарлахгүй.

1.5. Сайн дурын даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдөөгүй (13.5 хувь) хэвээр байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт сайн дураар даатгуулагчийн шимтгэл төлөх цалин хөлсний дээд хэмжээ сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар заасан.

Иймд сайн дураар даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний доод хэмжээ 660 000 төгрөг, дээд хэмжээ 4 620 000 төгрөг ( $660\,000 \cdot 7$ ) байна. Тухайлбал “09003” кодтой сайн дураар даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн доод хэмжээ 89 100 төгрөг ( $660\,000 \cdot 13.5\%$ ), дээд хэмжээ 623 700 төгрөг ( $4\,620\,000 \cdot 13.5\%$ ) байна.

Сайн дурын даатгалын гэрээнд “Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны шийдвэрээр шинэчлэн тогтоосон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж мөрдөнө” гэж заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000)-нээс 659 999 төгрөгийн хоорондох орлогоос шимтгэл төлөхөөр байгуулсан гэрээний хугацаа нь 2024 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд

2024 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн шимтгэл ногдуулан төлөх орлогын хэмжээг 660 000 төгрөгөөр өөрчилнө.

Даатгуулагч цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо 4 620 001 төгрөгөөс 5 500 000 төгрөг байхаар мэдүүлж байгуулсан сайн дурын даатгалын гэрээний хугацаа нь 2024 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн шимтгэл төлөх сарын орлогын дээд хэмжээг 4 620 000 төгрөгөөр өөрчилнө.

Сайн дурын даатгалын гэрээний маягт шинэчлэн батлагдаж байгаатай холбогдуулан даатгуулагчийн гэрээний хугацаа 2024 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд уг гэрээний хугацаанд гэрээний маягтыг солихгүй. Харин 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр байгуулсан болон өмнө байгуулсан гэрээний хугацаа дууссан тохиолдолд сайн дурын даатгалын шинэчлэгдсэн гэрээний маягтаар гэрээг байгуулна.

1.5.1. Хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийг програмд “64004”, “65004”, “64014”, “65014” кодоор бүртгэнэ. Даатгуулагч эхийн сайн дурын даатгалын гэрээний хугацаа (хүүхдийг нь 3 нас хүртэл)-нд гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа шимтгэл төлөх цалин хөлсний хэмжээгээ өөрчилж болно.

Даатгуулагч эх гэрээний хугацаанд дахин хүүхэд төрүүлбэл шинээр төрсөн хүүхдийн мэдээллээр гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээг шинэчлэх хүсэлт гаргах хүртэлх хугацааны шимтгэлийг даатгуулагчаар бүрэн төлүүлнэ.

1.5.2.Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ (цаашид “байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/” гэх) сайн дураар даатгуулах тохиолдолд уг даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх бол даатгуулагчийн төрлийн “78004” кодоор, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх тохиолдолд даатгуулагчийн төрлийн “78014” кодоор програмд бүртгэнэ. Эдгээр даатгуулагчийн регистр болон иргэний бүртгэлийн дугаараар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сантай тулган шалгаж, гэрээ байгуулна. Даатгуулагчийн гэрээний хугацаа нь 12 сараас дээш байх тохиолдолд 12 сар тутамд нэг удаа цалин хөлсний хэмжээг өөрчилж болно.

1.5.3.Хөдөлмөрийн гэрээ байгуулснаас бусад малчин, туслах малчин сайн дураар даатгуулах тохиолдолд уг даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх бол даатгуулагчийн төрлийн “79004” кодоор, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх тохиолдолд даатгуулагчийн төрлийн “79014” кодоор программд бүртгэнэ. Малчин, туслах малчин даатгуулагчийн гэрээний хугацаа 1-12 сар байна. Сайн дураар даатгуулагч малчны шимтгэлийг улсын төсвөөс хариуцан төлөх нийт хугацааны дээд хэмжээ 5 жил /60 сар/ байна. Түүнчлэн малчин даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хугацаа (нийтдээ 20 жил эсхүл малчнаар ажилласан эрэгтэй 15 жил, эмэгтэй 12 жил 6 сард хүргэх)-нд хүртэл тухайн даатгуулагчийн шимтгэл

төлсөн хугацааг тооцоход 60 сарын дотор бол уг сарын тоогоор, 60 сараас дээш бол 60 сарын хугацаагаар улсын төсвөөс шимтгэлийг хариуцан төлнө.

Малчин, туслах малчин даатгуулагч гэрээ байгуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүний өмнөх (2023) оны “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тухайн оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл (цаашид “А” данс гэх), эсхүл туслах малчны хөдөлмөрийн гэрээг үндэслэнэ.

2023 оны жилийн эцсийн “А” дансны мэдээллийг Үндэсний статистикийн хороо 2024 оны 02 дугаар сараас төрийн мэдээлэл солилцооны “Хур” системд байршуулах талаар мэдээлэл өгсөн. Харин 2024 оны 01 дүгээр сард гэрээ байгуулах малчин нь 2023 оны “А” дансыг сум, баг, хорооны Засаг даргаас авч бүрдүүлж болно. Түүнчлэн малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 2022 оны “А” дансны мэдээллийг “Хур” системээр дамжуулан өгөх боломжтой талаар Үндэсний статистикийн хорооноос албан бичиг ирүүлсэн болно.

Цахимаар гэрээ байгуулах “79004”, “79014” кодтой даатгуулагч гэрээний дагуу эхний шимтгэлийг төлсөн ч хүсэлтийг нь хүлээн авсан байцаагч даатгуулагчийн цахимаар хавсаргасан “малчин” гэдгийг нотлох баримт бичгийг хянан шалгаснаар тухайн гэрээг хүлээн зөвшөөрч баталгаажуулна. Харин баталгаажуулах боломжгүй тохиолдолд гэрээг даатгуулагчид “баталгаажих боломжгүй” талаар мэдэгдэл өгөх тохиргоог програмд бүрдүүлсэн болно.

1.5.4.Сайн дураар даатгуулагч гэрээний хугацаандаа 3 хүртэл насны хүүхдээ асарч буй эх, малчин, туслах малчин, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ нөхцөлөөр гэрээг өөрчлөх хүсэлт гаргасан бол өмнөх гэрээгээр төлөхөөр тохирсон шимтгэлийн өргүй тохиолдолд дуусгавар болж, гэрээг шинээр байгуулна.

Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажилласан (даатгуулагчийн “02001” код) тохиолдолд сайн дурын даатгалтай давхардуулан шимтгэл төлж болно.

Сайн дураар даатгуулагчийн өмнө нь дуусгавар болсон эсхүл хүчингүй гэрээний хугацаанд төлөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй. Зөвхөн хүчин төгөлдөр байгаа гэрээний хугацаанд шимтгэлээ төлөөгүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу шимтгэлийг нөхөн төлүүлж, алданги тооцно.

“Нийгмийн даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө болон нийгмийн даатгалын сан, улсын төсвөөс хариуцан төлөх даатгуулагчийн төрөл, код”-ын жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7, 21 дүгээр зүйлд заасныг баримтлан шинэчлэн боловсруулж Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар хүргүүлээд байна.

Сайн дураар даатгуулагчийн төрөл, код, шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах цалин хөлс, нийгмийн даатгалын төрөл, хувь хэмжээ, өөрөө болон нийгмийн даатгалын сан эсхүл улсын төсвөөс төлөх шимтгэлийг хүснэгт 1-ээр хүргүүлэв.

Д/Д	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД	ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ	ШИМТГЭЛ ТООЦОХ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ОРЛОГО	ШИМТГЭЛ ТӨЛӨХ ХЭМЖЭЭ						Шимтгэлийн мөнгөн дүн			
				ТЭТГЭВЭР			ТЭТГЭМЖ			ҮОМШӨ	Нийт	Улсын төсөв болон тэтгэмжийн сэн	Даатгуулагчаас төлөх шимтгэлийн дүн
				УЛСЫН ТӨСВӨӨС	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС	ДААТГУУЛАГЧ	УЛСЫН ТӨСВӨӨС	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС	ДААТГУУЛАГЧ	ДААТГУУЛАГЧ			
1	09003	Сайн дураар даатгуулагч	Өөрөө мэдүүлсэн			11.5%			1%	1%	13.5%		
6	64004	ЖАТ авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх-ХХДоХ	ХХДоХ	5.75% (37950 төгрөг)	5.75% (37950 төгрөг)		0.5% (3300 төгрөг)	0.5% (3300 төгрөг)	1% (6600 төгрөг)	13.5%	41250	47850	
7	64014	ЖАТ тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх ХХДоХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДоХ-ний 5.75% (37950 төгрөг)	Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас тэтгэмжийн сангаас төлөх дүн (37950 төгрөг)-г хассан зөрүүгээр		ХХДоХ-ний 0.5% (3300 төгрөг)	Мэдүүлсэн орлогын 1 хувиас тэтгэмжийн сангаас төлөх дүн (3300 төгрөг)-г хассан зөрүүгээр	1%	13.5%	41250		
8	65004	ЖАТ аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх-ХХДоХ	ХХДоХ	5.75% (37950 төгрөг)	5.75% (37950 төгрөг)	0.5% (3300 төгрөг)		0.5% (3300 төгрөг)	1% (6600 төгрөг)	13.5%	41250	47850	
9	65014	ЖАТ аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх ХХДоХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДоХ-ний 5.75% (37950 төгрөг)	Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүн (37950 төгрөг)-г хассан зөрүүгээр	ХХДоХ-ний 0.5% (3300 төгрөг)		Мэдүүлсэн орлогын 1 хувиас улсын төсвөөс төлөх дүн (3300 төгрөг)-г хассан зөрүүгээр	1%	13.5%	41250		
14	78004	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг/-ХХДоХ	ХХДоХ	11.5% (75900 төгрөг)				1% (6600 төгрөг)	1% (6600 төгрөг)	13.5%	75900	13200	
15	78014	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг/-ХХДоХ-нээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДоХ-ний 11.5% (75900 төгрөг)	Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүн (75900 төгрөг)-г хассан зөрүүгээр			1%	1%	13.5%	75900		
16	79004	Сайн дураар даатгуулагч малчин, туслах малчин-ХХДоХ	ХХДоХ	5.75% (37950 төгрөг)	5.75% (37950 төгрөг)			1% (6600 төгрөг)	1% (6600 төгрөг)	13.5%	37950	51150	
17	79014	Сайн дураар даатгуулагч малчин, туслах малчин-ХХДоХ-ээс дээш	Өөрөө мэдүүлсэн орлого	ХХДоХ-ний 5.75% (37950 төгрөг)	Мэдүүлсэн орлогын 11.5 хувиас улсын төсвөөс төлөх дүн (37950 төгрөг)-г хассан зөрүүгээр			1%	1%	13.5%	37950		

Товчилсон үгийн тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, ЖАТ-Жирэмсний, амаржсаны тэтгэмж, ХХДоХ-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга-ын хэрэгжилтийн талаар:

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох шимтгэл төлсөн хугацааны, хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажилласан, эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох насны нөхцөлүүд өөрчлөгдөөгүй хэвээр байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийг 21 жил 9 сар ба түүнээс дээш хугацаанд төлсөн эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин мөн хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэн 2024 онд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (21 жил 9 сар)-г хангаагүй буюу 20-21 жил 8 сар шимтгэл төлсөн тохиолдолд төрсөн ондоо харгалзах тэтгэврийн насанд хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-19 жил 11 сар төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох даатгуулагч мөн төрсөн ондоо харгалзах тэтгэврийн насанд хүрсэн байна.

2.1.1. Өндөр насны тэтгэврийн нөхцөл (21 жил 6 сар шимтгэл хүртэл төлсөн, төрсөн ондоо харгалзах нас эрэгтэй 61 нас 6 сар, эмэгтэй 56 нас 6 сар)-ийг 2023 онд хангасан боловч тэтгэвэр тогтоолгох өргөдлөө 2024 онд гаргасан даатгуулагчид 2023 онд хангасан нөхцөлийн дагуу тэтгэвэр тогтооно.

2.1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй жил газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 45 насанд хүрсэн эмэгтэй” өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор шинэ нөхцөл нэмэгдсэн тул энэхүү нөхцөлийг хангасан эмэгтэй даатгуулагчид газрын доор нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтооно.

2.2. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4-т заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох эх тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (10 жил буюу 120 сар)-г хангасан тохиолдолд түүний нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэмэгдүүлнэ. Харин энэхүү хугацааг хангаагүй бол тухайн даатгуулагч эхийн шимтгэл төлж ажилласан хугацааг хүүхдийн тоогоор нэмэгдүүлэхгүй.

2.2.1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороогүй тул цэргийн алба хаагчийн төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор нэг жил зургаан сар шимтгэл төлснөөр тооцох, цэргийн алба хаасан хугацаанд шилжүүлэн тооцож цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоох зохицуулалтыг хэвээр мөрдөнө.

2.3. Тэтгэвэр бодох арга, сарын тэтгэврийн хэмжээг бодох томъёог хүснэгт-2 оор хүргүүлэв.

Хүснэгт-2

№	Тэтгэвэр бодох арга		
	Зөвхөн цалинд үндэслэсэн аргаар	Цалинд үндэслэсэн эсхүл нэрийн дансны аргаас даатгуулагч аль өөрт ашигтай аргаар бодуулах	Зөвхөн нэрийн дансны аргаар
1	<p>1.1960.01.01-ний өдрөөс өмнө төрсөн даатгуулагчид өндөр насны тэтгэвэр;</p> <p>2. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр;</p> <p>3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр;</p>	<p>1.1960.01.01-ний өдрөөс 1979.01.01-ний өдөр хүртэл төрсөн даатгуулагчид энгийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр;</p> <p>2. 1979.01.01-ний өдрөөс хойш төрсөн боловч хөнгөлөлттэй болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тогтоох тэтгэвэр;</p>	<p>1979.01.01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчид өндөр насны тэтгэвэр;</p>
Өндөр насны тэтгэвэр бодох томъёо			
	<p>Бүрэн тэтгэвэр:</p> $T_{цб} = Ц*(45%+(Ш_{241+}*0.125%))$ <p><math>T_{цб}</math>- сарын тэтгэврийн хэмжээ; Ц- сарын дундаж цалин хөлс; <math>Ш_{241+}</math> - 241 ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо;</p> <p>Хувь тэнцүүлсэн тэтгэвэр:</p> $T_{цх} = Ц*0.1875%*Ш_{сар}$ <p><math>T_{цх}</math>- сарын тэтгэврийн хэмжээ; Ц-сарын дундаж цалин хөлс; <math>Ш_{сар}</math>- шимтгэл төлсөн сарын тоо;</p>	$T_{цб} = Ц*(45%+(Ш_{241+}*0.125%))$ <p><math>T_{цб}</math>- сарын тэтгэврийн хэмжээ; Ц- сарын дундаж цалин хөлс; <math>Ш_{241+}</math> - 241 ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо;</p> $T_{нд} = НД_{сз} / 12К$ <p><math>T_{нд}</math>- сарын тэтгэврийн хэмжээ; НД<sub>сз</sub>- нэрийн дансны эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүн; К- тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл;</p>	$T_{нд} = НД_{сз} / 12К$ <p><math>T_{нд}</math>- сарын тэтгэврийн хэмжээ; НД<sub>сз</sub>-нэрийн дансны эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүн; К-тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл;</p>

2.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж албан журмаар даатгуулан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийн хэмжээг нь анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлснөөс тооцон шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд (1, 2, 3, 4, 5 сар гэх мэт тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөд) тэтгэврийг нэмэгдүүлнэ. Харин тэтгэвэр авагч хүсэлт гаргаагүй тохиолдолд нэмэгдлийг хийхгүй бөгөөд тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 6 сар ба түүнээс дээш хугацаанд шимтгэл төлсөн нөхцөлд тэтгэврийг өөрчлөн тогтоож болно.

2.4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн 2019 онд дараалсан зургаа, 2020-2023 онд дараалсан долоон жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоох бөгөөд бусад тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосон цалинг өөр онуудын цалингаар өөрчлөхгүй.

2.5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт "Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тогтоосон тэтгэврийг энэ хуулийн 25.1, 29.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд өөрчлөн тогтоохгүй" гэж заасан тул тэтгэвэр тогтоолгосон дундаж цалинг өөр онуудын цалингаар сольж өөрчлөн тогтоохгүй.

Харин тэтгэврээ дундаж цалин хөлсгүйгээр тогтоолгосон тэтгэвэр авагч нь дараалсан 5 жилийн цалин хөлсөөр, эсхүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалаар баталсан жишиг цалингаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд уг цалин хөлсийг Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан итгэлцүүрээр өсгөн, цалин хөлсний сарын дээд хэмжээг баримтлан дундаж цалин хөлсөөр тооцон тэтгэврийг нь өөрчлөн тогтооно. Түүнчлэн тухайн тэтгэвэр авагч нь 2023.07.01-ний өдрөөс өмнө тэтгэврээ тогтоолгосон бол уг тэтгэврийг нь Засгийн газрын 2023 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дүгээр тогтоолын дагуу 10 хувиар нэмэгдүүлж, сарын тэтгэврийн хэмжээг шинэчлэн тогтооно. Мөн хугацаанаас хойш тэтгэврээ тогтоолгосон бол 10 хувийн нэмэгдэл тооцохгүй.

2.6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний авч байсан сарын тэтгэврийн 20 хувиар тооцсон дүнгээр нөхөр эсхүл эхнэрийн сарын тэтгэврийг нь нэмэгдүүлэхээр заасан. Энэ тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна:

-Тухайн гэр бүлийн хоёр гишүүн хоёулаа нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх. Өөрөөр хэлбэл хоёр тэтгэвэр авагчийн аль нэг нь хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр тогтоолгосон бол 20 хувийн нэмэгдлийг тооцон олгохгүй.



-Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар гэрлэлтээ бүртгүүлсэн байх ба нас барсан болон гэр бүлийн гишүүн тэтгэвэр авагчийн гэрлэлтийн бүртгэлийг УБЕГ-ын системээр авах, уг системээс авах боломжгүй тохиолдолд гэрлэлтийн гэрчилгээг хуулбарлан мэдээллийн санд оруулах, түүнчлэн гэрлэлтийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд УБЕГ-ын лавлагаа авна.

-20 ба түүнээс дээш жил хамт амьдарсныг гэрлэлтийн гэрчилгээг үндэслэн тооцно. Өөрөөр хэлбэл гэрчилгээнд бичигдсэн гэрлэсэн, гэрлэлтийг бүртгэсэн хугацааг баримтлана.

Түүнчлэн тэтгэвэр авагчдын гэрлэлтээ бүртгүүлсэн хугацаа нь 20 жилээс дотогш тохиолдолд хүүхдийн эцгээрээ овоглож, эцгийн болон эхийн овог нэр, регистр бичигдсэн төрүүлсэн хүүхдийн гэрчилгээний хуулбар (тухайн хүүхэд нь 20 нас ба түүнээс дээш настай байх)-ыг үндэслэж болно. Харин 20 жил ба түүнээс дээш жил хамт амьдарсныг нотлох баримт бичиггүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэнэ. Дээрх шалгуурыг хангасан тохиолдолд тэтгэврийн нэмэгдлийг нас барсан тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас тооцож олгоно. Тухайлбал, тэтгэвэр авагч 1 дүгээр сард нас барсан бол түүний нас барсны дараагийн сар буюу 2 дугаар сарын тэтгэврийг олгоод 3 дугаар сараас эхлэн нөхөр эсхүл эхнэрт нь 20 хувиар тооцсон нэмэгдлийг олгоно. Хуулийн энэ зохицуулалтад нийгмийн халамжийн болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч хамаарахгүй.

2.7. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.” гэж заасан тул эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаагаа тогтоолгон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байхдаа нийгмийн даатгалд албан журмаар эсхүл сайн дураар даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоохгүй.

2.8. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх нас барсан даатгуулагчийн асрамжид байсан гэр бүлийн гишүүдийн төрөлд өөрчлөлт орсон тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг баримтална.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу тэжээгчийг сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд 60 хүртэлх сарын тэтгэврийг түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд нөхөн олгоно. Энэ тохиолдолд тэжээгчийн нас барсныг тогтоосон хугацаа 60 сарын дотор бол уг сарын тоогоор, 60 сараас дээш бол 60 сарын тэтгэврийг нөхөн олгоно.

Түүнчлэн нас барсан тэжээгч нь тэтгэвэр авагч бол түүний тэтгэврийг нөхөн олгохдоо тэтгэврийг зогсоосон сараас хойш нас барснаар тооцогдсон хугацаа нь 60 сарын дотор бол уг сарын тоогоор, 60 сараас дээш бол 60 сарын хугацаагаар олгоно.

2.9. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр гарсан өдрөөс тэтгэвэр олголтыг сэргээж, 60 сарын тэтгэврийг нөхөн олгохоор заасан. Энэ тохиолдолд уг хугацаа 60 сарын дотор бол уг сарын тоогоор, 60 сараас дээш бол 60 сарын тэтгэврийг өмнө авч байсан тэтгэврийн хэмжээгээр тооцон нөхөн олгоно.

2.10. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барснаас хойш 30 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор нийгмийн даатгалын байгууллагад цаасаар эсхүл цахимаар гаргахаар заасан тул уг хугацааг баримтлана.

2.11. Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт 14 ба түүнээс доош насны хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-д олгоно гэж заасан.

Иймд 2024.01.01-ний өдрөөс эхлэн тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 14 насанд хүрсэн иргэн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд тухайн хүүхдийн нэр дээр тэтгэвэр тогтоож болно. Энэ тохиолдолд 2 ба түүнээс дээш хүүхэдтэй тэжээгчээ алдсаны тэтгэврийн 14 нас хүрсэн хүүхдэд тусад нь тэтгэвэр тогтоохгүй.

2.12. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн шинээр тогтоосон өндөр насны тэтгэврийн хэмжээ нь өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс буурахаар бол өндөр насны тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээгээр тогтоож олгоно. Энэ зохицуулалт үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход мөн хамаарна. Харин цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид хамаарахгүй.

2.13. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу хоёр тэтгэвэр авах эрх зэрэг үүсэхээр бол шимтгэл төлсөн болон цэргийн алба хаасан хугацааг нэгтгэн тооцож нэг тэтгэвэр тогтоохоор заасан. Энэ тохиолдолд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр тэтгэвэр тогтоолгох хүний хүсэлтэд үндэслэн тэтгэврийн даатгалын сангаас эсхүл цэргийн тэтгэврийн аль өөрт нь ашигтай тэтгэврийг тогтооно. Өөрөөр хэлбэл цаашид цэргийн алба хаасны болон нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийг тус тусад нь тогтоохгүй.

Дээрх өөрчлөлт нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчид хамаарахгүй, тухайн тэтгэвэр авагч нь асран хамгаалагч /мөнгө авагч/-аар тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч бол мөн хамаарахгүй.

2.14. Нийгмийн даатгалын сангаас тогтоож, олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж болон цэргийн тэтгэврийг тооцоход баримтлах сарын цалин хөлсний дээд хэмжээг 2024 онд албан журмын даатгуулагчид 6 600 000 төгрөг, сайн дураар даатгуулагчид 4 620 000 төгрөгөөр тооцно.

2.15. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны сарын бүрэн тэтгэврийн доод хэмжээ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 660 000 төгрөг байна. Энэ зохицуулалт Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэрт мөн адил хамаарна.

Харин Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна” гэж заасан тул Засгийн газрын 2023 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолоор баталсны дагуу цэргийн тэжээгчээ алдсаны 3 буюу түүнээс дээш хөдөлмөрийн чадваргүй гишүүнд олгох тэтгэврийн доод хэмжээ сард 550 000 төгрөг хэвээр байна.

2.16. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, өөрчлөхөд баримтлах журам”-ын 2.2.1-д даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ажилд томилсон, ажлаас чөлөөлөгдсөн тухай тушаал шийдвэр бүрдүүлэхээр заасан. Журмын энэ заалтыг хэрэгжүүлэхдээ даатгуулагч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан бол тухайн ажил, мэргэжлээр томилсон, чөлөөлсөн тушаал, шийдвэрийг, бусад тохиолдолд зөвхөн ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэрийг бүрдүүлнэ.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын хэрэгжилтийн талаар:

3.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх дараалсан гурав ба түүнээс дээш сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй” гэж заасан тул даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсан сарын өмнөх 3 сард дараалан тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд тэтгэмж олгоно. Хэрэв даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан сарын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 3 сар нь тасралттай бол тэтгэмжийн эрх үүсэхгүй.

3.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно”, мөн хуулийн 11.2 дахь хэсэгт “Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.” гэж тус тус заасны дагуу даатгуулагчийн тэтгэмж тооцон олгох өдөрт тохиосон нийтээр тэмдэглэх баярын өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож тэтгэмж бодно. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2-т

“Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3”-нд нийтээр амрахаар заасан. 2024 оны билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдөр нь 2024 оны 02 дугаар сарын 10-13-ны өдөр тохиож байна. Эдгээрээс 02 дугаар сарын 10-ны өдөр бямба, 11-ний өдөр ням гаригт таарч байгаа тул энэхүү 02 дугаар сарын 10, 11-ний амралтын өдрийг ажлын өдрөөр тооцон жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгоно.

Мөн тэтгэмж авах өргөдлийг 2023 онд гаргасан даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хугацаа нь 2024 он дамжин нийтээр амрах баярын өдөр тохиосон бол тэтгэмж бодох ажлын өдөрт оруулан тооцож дээрх тэтгэмжүүдийг дахин тооцож нөхөн олгоно.

3.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгоно. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 1.6-д хуанлийн жилийн нэг сарын дундаж ажлын өдрийг 21 өдрөөр тооцохоор заасан тул даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр адсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж тооцох сарын дундаж цалин хөлсийг 21-т хувааж тооцно.

Даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж тооцох сүүлийн дараалсан 3, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцох сүүлийн 12, ажилгүйдлийн тэтгэмж тооцох сүүлийн дараалсан 9 сарын цалин хөлсний бүрэлдэхүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доош цалин хөлс орсон тохиолдолд уг цалин хөлсийг тэтгэмж бодох дундаж цалин тооцоход оруулна.

3.4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай” 08 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2024 онд 2 000 000 төгрөг (хоёр сая)-өөр, тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 төгрөг (гурван сая таван зуун мянган)-өөр тогтоосныг баримтлан олгоно.

3.5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй” гэж заасан.

Иймд даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох ердийн насыг тухайн даатгуулагчийн төрсөн онд харгалзах тэтгэврийн нас гэж ойлгоно. Тухайлбал Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Тайлбар:” хэсэгт заасан даатгуулагчийн тэтгэврийн нас нь 2024 онд эрэгтэй 61 нас 09 сар, эмэгтэй 56 нас 09 сар, 2025 онд эрэгтэй 62 нас, эмэгтэй 57 нас ... гэх зэрэг болно.

3.6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт “Цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар татагдсан, хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, байгууллагын захиалгаар суралцах, хөдөлмөрийн чадвар алдсаны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.” гэж заасан тул энэ зөвлөмжийн 3.5-д заасан тэтгэврийн насанд хүрээгүй боловч хөдөлмөрийн чадвар алдсаны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

3.7. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Ажилгүйдлийн тэтгэмж урьд нь авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж авах эрх дахин үүснэ” гэж заасны дагуу даатгуулагчийн ажлаасаа халагдсан сарын өмнөх ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаа 12 сар, мөн ажлаас халагдсан сарын өмнөх 3 сард тасралтгүй шимтгэл төлсөн буюу дараалсан нөхцөлийг хангасан даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг дахин олгоно.

3.8. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Хүүхдээ асрах чөлөө авахаас өмнө энэ хуулийн 9.1-д заасан эрхийг хангасан даатгуулагч эхийг хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд ... ажил олгогч нь татан буугдсан, дампуурсан бол түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгоно” гэж заасан. Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргахад хүүхдээ асрах чөлөөтэй байсан бол уг чөлөөг авахын өмнө энэ зөвлөмжийн 3.5-д заасан ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааны нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд чөлөө авахын өмнөх сүүлийн дараалсан 9 сарын цалин хөлсний дунджаас ажилгүйдлийн тэтгэмжийг бодож, олгоно.

Энэ тохиолдолд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллага нь татан буугдсан хуулийн этгээдийн тухай мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулснаар тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанд тооцно” гэж заасны дагуу уг мэдээллийн санд бүртгэгдсэн ажил олгогчийг татан буугдсан гэж үзнэ.

3.9. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт “Даатгуулагч энэ хуулийн 14.1.3-т заасан хугацаанаас хойш ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон холбогдох баримт бичгийн хамт нийгмийн даатгалын байгууллагад бүрдүүлж өгсөн бол уг хугацаанаас хоцроосон ажлын өдрийг энэ хуулийн 11.1-д заасан өдрөөс хасаж тооцон ажилгүйдлийн тэтгэмж олгоно” гэж заасны дагуу даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлөө ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн тушаал шийдвэр гарсан өдрөөс хойш 28 хоногийн (хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын) дотор гаргаагүй бол тухайн хоцроосон ажлын өдрийг ажилгүйдлийн тэтгэмж олгох ажлын 76 өдрөөс хасаж үлдсэн хугацаанд ногдох тэтгэмжийг бодож, олгоно.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын хэрэгжилтийн талаар:

4.1. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоох сарын дундаж цалинг тооцохдоо энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.4, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт тус тус заасныг баримтлана. Ажилтан 1 сараас доош хугацаанд ажиллаж байх үедээ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол ажилд томилсон шийдвэрээр тогтоосон цалин хөлсний хэмжээгээр тухайн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгуулан, шимтгэлийг төлүүлснээр уг шимтгэлийг төлсөн цалин хөлснөөс даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгоно.

4.2. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоох сарын дундаж цалинг тооцохдоо энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар ... нэмэгдүүлнэ” гэж заасан.

Энэ тохиолдолд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 12 сараас доошгүй хугацаанд даатгуулагчийн төрлийн “22001” кодтой өндөр насны, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан, “34001” кодтой сул зогсолтын үеийн олговор авч байгаа тэтгэвэр тогтоолгосон ажилтан, “38002” кодтой тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа жирэмсний болон амаржсаны амралттай ажилтан, “39002” кодтой тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа хөдөлмөрийн чадвараа 1 сараас дээш хугацаанд алдсан ажилтан, “70001” кодтой хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэврийг нэмэгдүүлнэ. Тухайн даатгуулагчийн хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд 12 сараас доош хугацаанд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сараар тооцон тэтгэврийг нь нэмэгдүүлж болно.

4.3. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас, эсхүл нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй” гэж заасан. Даатгуулагч протез, ортопедийн зардалын төлбөр гаргуулах хүсэлт гаргасан тухайн жилд эрүүл мэндийн даатгалын болон нийгмийн халамжийн байгууллагаас уг зардлыг авсан эсэхийг шалгах, давхардуулан олгохгүй байх боломж бүрдүүлэх

зорилгоор эдгээр байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох бэлтгэл ажлыг хангаж байна.

4.4. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нас барсан бол түүний ямар шалтгаан нөхцөлөөр нас барснаас үл хамааран гэр бүлийн гишүүнд тэтгэмж (2 000 000 төгрөг, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн бол 3 500 000 төгрөг) олгоно.


Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх явцад үүссэн тулгамдсан асуудлыг тус газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт тухай бүр хандан шуурхай шийдвэрлүүлж байх нь зүйтэй.

Иймд Нийгмийн даатгалын багц хуулийн эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, байцаагч, ажилтнууд, ажил олгогч, иргэд, даатгуулагчдыг мэдээллээр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийгмийн даатгалын газрын дарга нарт үүрэг болгож байна.

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 422 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардалын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам”, 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”, 439 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам”, “Тогтоол хүчингүй болгох тухай” 440 дүгээр тогтоол, 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан А/177, А/433 тушаалаар баталсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”, “Эмнэлгийн хуудасны маягтын загвар”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”, Үндэсний статистикийн хорооны 2023 оны “Хариу хүргүүлэх тухай” 01/1105 дугаар албан бичгийн хуулбарыг тус тус хүргүүлэв.

Хавсралт <sup>47</sup> хуудастай.

ДАРГА



Л.МӨНХЗУЛ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.10-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



Засгийн газрын 2023 оны 11 дүгээр  
сарын 29 -ний өдрийн 122 дугаар  
тогтоолын хавсралт

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ДААТГУУЛАГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТӨЛБӨР АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ БОЛОН ТӨЛБӨРИЙГ ОЛГОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.10-д заасны дагуу даатгуулагчид протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр олгох, санхүүжүүлэхэд энэ журмыг баримтална.

1.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй.

### Хоёр.Зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, ортопедийн зардлын төлбөр авах хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ:

2.1.1.төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүгнэлт, эсхүл эрүүл мэндийн байгууллагын шийдвэр;

2.1.2.протез, ортопед хийлгэсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн).

2.2.Сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний байгууллага нь сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг авах хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ:

2.2.1. тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн мэдээлэл (овог, нэр, регистрийн дугаар);

2.2.2. төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн).

2.3. Даатгуулагч сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг авах хүсэлтийг унааны зардал төлсөн баримтын хамт харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

Гурав. Протез, ортопедийн зардлын төлбөр олгох

3.1. Протез, ортопедийн зардлын төлбөр авах даатгуулагч харьяа нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 2.1-д заасан баримт бичийг бүрдүүлэн энэ журмын 2.1.2-т заасан нэхэмжлэх бичигдсэн өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор хүсэлтээ гаргана.

3.2. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг үндэслэн, жишиг үнийг баримтлан төлбөрийг 3 жил тутамд нэг удаа олгоно.

3.3. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг үндэслэн төлбөр олгохдоо хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актын мэдээллийг холбогдох мэдээллийн санд үндэслэн цахимаар шалгана.

3.4. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор протез, ортопедийн зардлын төлбөрийг эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас бэлэн бусаар шилжүүлнэ.

3.5. Даатгуулагчийн дахин хийлгэсэн протез, ортопедийн төлбөрийг олгохдоо энэ журмыг баримтална.

3.6. Энэ журмын 2.1.2-т заасан нэхэмжилсэн төлбөрийн дүн нь тухайн протез, ортопедийн жишиг үнээс бага бол нэхэмжилсэн үнийн дүнгээр, их бол жишиг үнийг баримтална.

3.7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид протез, ортопедийн засвар, үйлчилгээний төлбөр олгохгүй.

3.8. Даатгуулагч гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн зардлын төлбөрийг авахдаа энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад цаасаар, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

3.9.Гадаад улсад амьлгэсэн гэрлээ, орлогын зардлын төлбөр олгохдоо энэ журмын 3.4-т заасныг баримтална. Хэрэв даатгуулагч төлбөрөө өөрөө төлсөн бол баримтыг үндэслэн даатгуулагчийн дансанд 14 хоногийн дотор бэлэн бусаар шилжүүлнэ.

Дөрөв.Сэргээн засах болон сувиллын тусламж,  
үйлчилгээний зардлын төлбөр олгох

4.1.Сэргээн засах төв болон сувилал нь сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг авах хүсэлтийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 2.2-т заасан баримт бичиг бүрдүүлэн сар бүр гаргана.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох зардлыг эрх бүхий байгууллагын тогтоосон хэмжээг баримтлан энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сэргээн засах төв болон сувилалд бэлэн бусаар олгоно.

4.3.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 4.2-т заасны дагуу зардлын төлбөрийг олгохдоо энэ журмын 3.3, 5.3-т заасны дагуу холбогдох мэдээллийг шалгана.

Тав.Сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах  
унааны зардлын төлбөр олгох

5.1.Даатгуулагч сэргээн засах төв болон сувилалд сувилуулснаас хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор энэ журмын 2.3-т заасан баримт бичиг бүрдүүлэн харьяа нийгмийн даатгалын байгууллагад ирэх, буцах унааны зардлын төлбөр авах хүсэлт гаргана.

5.2.Нийгмийн даатгалын байгууллага сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тухайн үед мөрдөж байгаа үнийг үндэслэн энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор даатгуулагчид бэлэн бусаар олгоно.

5.3.Энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн зардлын төлбөрийг олгохдоо энэ журмын 3.3-т зааснаас гадна нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн тухайн даатгуулагчийг сэргээн засах төв болон сувилалд сувилуулсан эсэхийг цахимаар шалгана.

Зургаа.Санхүүжүүлэх, хяналт тавих

6.1.Энэ журмын дагуу олгох төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

6.2.Сангийн хөрөнгийн зарцуулалтад нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Төв зөвлөл, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар тус тус хяналт тавьж ажиллана.

#### Долоо.Тайлагнах

7.1.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар даатгуулагчид олгосон протез, ортопедийн зардлын төлбөрийн тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.2.Даатгуулагчид олгосон сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр, сэргээн засах төв болон сувилалд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон зардлын төлбөрийн тайланг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар улирал бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### Найм.Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

## ДААТГУУЛАГЧ ТЭТГЭМЖ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох болон ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, даатгуулагчид тэтгэмж олгох харилцааг зохицуулна.

### Хоёр.Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1.Нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр даатгуулсан даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахад эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалд албан журмын хэлбэрээр даатгуулсан даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан бол ажил олгогч дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

2.2.2.тэтгэмж авах даатгуулагчийн мэдээлэл (овог, нэр, регистр, банкин дахь дансны дугаар).

2.3.Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахад эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.4.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.4.1.даатгуулагчийн нас барсны гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

2.4.2. гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

2.4.3.амьгүй донор болсон тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт.

2.5.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.5.1. даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр, шийдвэрт хамаарах хугацаа нь дуусгавар болж буй ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон эдгээртэй адилтгах бусад гэрээний хамт;

2.5.2. хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.

2.6. Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах бол энэ журмын 2.1, 2.3-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

2.7. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах бол энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

2.8. Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах бол энэ журмын 2.5-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр гарсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор хүсэлт гаргана.

2.9. Ажил олгогч энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор хянаж хүргүүлнэ.

2.10. Энэ журмын 2.6, 2.7, 2.8, 2.9-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2.1.5-д заасныг ойлгоно.

2.11. Ажил олгогч, даатгуулагч тэтгэмж авах цахим өргөдөл, баримт бичгийг нийгмийн даатгалын байгууллагад холбогдох цахим системээр илгээнэ.

2.12. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг үндэслэн, энэ журмын 2.4.1-д заасан даатгуулагчийн нас барсны гэрчилгээ, 2.5.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолтыг холбогдох байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлно.

Гурав. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох

3.1. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчаас, энэ журмын 2.1, 2.3-т заасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, даатгуулагчийн арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.2. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 24 цагийн дотор шийдвэрлэж, гэр бүлийн гишүүнд арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.3. Даатгуулагчид ажил олгогчоос олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг ажил олгогч, нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид арилжааны банкин дахь дансаар дамжуулан олгоно.

3.4. Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахад нийгмийн даатгалын байгууллагад дахин хүсэлт гаргахгүй, эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг үндэслэн олгоно.

3.5. Даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон өвчний оношоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохгүй.

3.6. Энэ журмын 2.6, 2.7, 2.8, 2.9-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд даатгуулагчид тэтгэмж олгохгүй.

#### Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олгох

4.1. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.5-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, даатгуулагчийн арилжааны банкин дахь дансаар дамжуулан сар бүр олгоно.

4.2. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа даатгуулагчид зөвхөн үндсэн ажлаасаа халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

4.3. Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон боловч анх тэтгэмж олгохоор тогтоосон хугацаа дуусахаас өмнө ажлаас халагдсан тохиолдолд түүнд үлдэх хугацаанд ногдох тэтгэмжийг урьд авч байсан хэмжээгээр нь үргэлжлүүлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

4.4. Даатгуулагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон бол нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэж, тэтгэмж олголтыг зогсооно.

4.5. Даатгуулагч үндсэн ажлаас халагдсаны дараагийн өдрөөс эхлэн давхар ажиллаж байгаа аль нэг байгууллагын үндсэн даатгуулагчаар шилжин шимтгэл төлж, ажилласан тохиолдолд түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

#### Тав. Бусад

5.1. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа, олгосон дүн зэрэг мэдээллийг цахим үйлчилгээний нэгдсэн систем, даатгуулагчийн веб систем, нийгмийн даатгалын аппликейшн зэрэг системээр цахимаар хүргэнэ.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 11.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн 439 дүгээр тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН  
САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ  
БИЧГИЙН ЖАГСААЛТ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгоход энэ журмыг баримтална.

1.2.Ажил олгогч даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг хуульд заасан хугацаанд бүрдүүлж өгнө.

Хоёр.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

2.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.1.1.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт";

2.1.2.даатгуулагчийг ажилд томилсон тухай тушаалын хуулбар;

2.1.3.даатгуулагчийн цалин, хөлсний тодорхойлолт (1 сараас доош хугацаанд ажилласан тохиолдолд).

2.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход энэ журмын 2.1-д заасан болон дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.тэжээгчийн нас барсны гэрчилгээ, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

2.2.2.тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

2.2.3.гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр.

Гурав.Тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх  
баримт бичгийн жагсаалт

3.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.1.1.эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

3.1.2.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт".

3.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авахад дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.2.1.даатгуулагчийн нас барсны гэрчилгээний хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа, шүүхийн шийдвэр;

3.2.2.даатгуулагчийн гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл эрх бүхий байгууллагын лавлагаа;

3.2.3.даатгуулагч амьгүй донор болсон тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт.

Дөрөв.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход  
шаардагдах баримт бичиг

4.1.Тэтгэвэр авагч тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоолгох бол дараах баримт бичгийг өргөдлийн хамт цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

4.1.1.тэтгэвэр тогтоолгоход баримталсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдсон тухай баримт;

4.1.2.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаанд өөрчлөлт орсон тухай эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

4.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоонд өөрчлөлт орсон тухай баримт;

4.1.4.тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тухай баримт.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 4.1.1, 4.1.2, 4.1.4-т заасан баримт бичгийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тодорхойлно.

Тав.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан  
өвчний даатгалын сангаас тэтгэвэр олгох

5.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон өдрөөс хойш

14 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор хүсэлт гаргана.

5.2. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад тэжээгч нас барснаас хойш 30 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор хүсэлт гаргана.

5.3. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийг тэтгэвэр авагчийн сонгосон банкаар дамжуулан сар бүр олгоно.

5.4. Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн сарын тэтгэврийг энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг үндэслэн банкаар дамжуулан тухайн сард нь багтаан олгоно.

5.5. Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох өргөдөл, шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

5.6. Даатгуулагч энэ журмын 5.1, 5.2-т заасан хугацаанаас хойш тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж болно.

5.7. Даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж авах цахим өргөдөл, баримт бичгийг нийгмийн даатгалын байгууллагад холбогдох цахим системээр илгээнэ.

Зургаа. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэмж олгох

6.1. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах бол энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 7.4.3-т заасан баримт бичиг баталгаажсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор гаргана.

6.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг өргөдлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад тэжээгч нь нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор гаргана.

6.3. Нийгмийн даатгалын байгууллага хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн баримт бичиг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчийн сонгосон банкаар дамжуулан олгоно.

6.4. Нийгмийн даатгалын байгууллага нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг баримт бичиг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэрлэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас банкаар дамжуулан олгоно.

6.5.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны нэг сараас дээш хугацааны тэтгэмжийг 14 хоног тутам бодож олгоно.

6.6.Энэ журмын 6.1, 6.2-т заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд даатгуулагчид тэтгэмж олгохгүй.

6.7.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа, олгосон дүн зэрэг мэдээллийг цахим үйлчилгээний нэгдсэн систем, даатгуулагчийн веб систем, нийгмийн даатгалын аппликейшн зэрэг цахимаар хүргэж болно.

#### Долоо.Бусад зүйл

7.1.Даатгуулагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг өөрийн биеэр бүрдүүлэх боломжгүй бол хууль ёсны төлөөлөгч нь дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

7.1.1.тэтгэвэр авагчийн хууль ёсны төлөөлөгч болон тэтгэвэр авагч иргэн эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, чадамж хязгаарлагдсан бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тодорхойлсон шийдвэр;

7.1.2.хууль ёсны төлөөлөгч болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх.

7.2.Энэ журмын 7.1-д заасан хууль ёсны төлөөлөгч тэтгэвэр авах бол энэ журмын 2.1, 2.2, тэтгэмж авах бол энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

7.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох бол энэ журамд заасан баримт бичгээс гадна эрх бүхий байгууллагын олгосон Монгол Улсад байнга оршин суудаг болохыг баталгаажуулсан баримт бичгийг бүрдүүлнэ.

7.4.Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр, тэтгэмж тогтооход нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан болон холбогдох цахим мэдээллийн санг үндэслэн дараах мэдээллийг тодорхойлно. Үүнд:

7.4.1.нийгмийн даатгалын шимтгэл төлөлт;

7.4.2.хөдөлмөрийн чадвар алдсан тухай эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

7.4.3.хөдөлмөрийн, эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт";

7.4.4.нас барсны, төрсний, гэрлэлтийн гэрчилгээ.

7.5.Энэ журмын 5.1, 5.2, 6.1, 6.2, 7.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д зааснаар ойлгоно.

7.6.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 440

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 361 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай мэдээллийг нийгмийн даатгалын байгууллагатай цахимаар солилцох ажлыг зохион байгуулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



Засгийн газрын 2023 оны 12 дугаар  
сарын 20-ны өдрийн 160 дугаар  
тогтоолын хавсралт

## ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ, ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХӨД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ, ТЭТГЭВЭР ОЛГОХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгох болон тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход бүрдүүлэх баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлэх, тэтгэвэр тогтоож олгоход энэ журмыг баримтална.

1.2.Тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан даатгуулагчийн шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, үрэгдүүлсэн баримт бичгийн мэдээлэл нь нийгмийн даатгалын байгууллагын архив, мэдээллийн нэгдсэн санд байгаа тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газраас гаргуулж, харилцан солилцох зарчмыг баримтална.

### Хоёр.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчид тогтоох тэтгэврийн төрлөөс хамаарч доор дурдсан шаардлагатай мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, нийгмийн даатгалын байгууллагын архив болон төрийн мэдээлэл солилцох үндсэн системээс тодорхойлно:

2.1.1.иргэний үнэмлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад байнга оршин суух үнэмлэх;

2.1.2.ажил олгогчийн 1991-1994 онд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тодорхойлолт;

2.1.3.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

2.1.4.ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн тухай мэдээлэл;

2.1.5.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн тухай мэдээлэл;

2.1.6.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоол;

2.1.7.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр, акт;

2.1.8.нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгоогүй тухай хөдөлмөр, нийгмийн халамжийн байгууллагын тодорхойлолт;

2.1.9.тэжээгчийн нас барсны гэрчилгээ;

2.1.10.гэрлэлт бүртгэсэн лавлагаа;

2.1.11.хүүхдийн төрсний гэрчилгээ;

2.1.12.үрчлэлтийн талаарх лавлагаа;

2.1.13.ургийн овог, овог нэр, регистр, ажил олгогчийн нэр, өмчийн хэлбэр өөрчилсөн лавлагаа.

2.2.Даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.2.1.ажилд томилсон, ажлаас чөлөөлөгдсөн тухай тушаал, шийдвэр;

2.2.2.1995 оноос өмнө ажилласан хугацааг нотлох хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр;

2.2.3.цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа;

2.2.4.тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын лавлагаа (1995 оноос өмнөх хугацааны);

2.2.5.итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх, итгэмжлэл;

2.2.6.ургийн овог, овог нэр, регистр, ажил олгогчийн нэр, өмчийн хэлбэр өөрчилсөн лавлагаа.

2.3.Малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход энэ журмын 2.2-т заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт, бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.3.1.1995 оноос хойших хугацаанд мал маллаж, шимтгэл төлж байсан хугацааг нь нотлох боломжгүй бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоол;

2.3.2.ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1990-1994 оныг нөхөн тооцуулсан бол тухайн орон нутагт мал маллан оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

2.3.3.Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын бүртгэл "А" данс малчны гэр бүлийн гишүүдийн мэдээллийг "А" дансны 2 дугаар бүлэг дэх "Малчны мэдээлэл" хэсэгт бүртгэгдсэн хүний мэдээлэлтэй тулган гаргасан лавлагаа (ХААТР 11);

2.3.4.тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан эмэгтэй малчин даатгуулагчийн гэрлэсэн эсэх тухай шүүхийн шийдвэр.

2.4.Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан баримт бичгээс өөрт холбогдох баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2.5.Даатгуулагч тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход энэ журмын 2.2-т заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

2.5.1.гэрлэсэн эсэх тухай шүүхийн шийдвэр;

2.5.2.асран хамгаалагчаар тогтоосон тухай харьяа аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамж;

2.5.3.тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох хүсэлт, шүүхийн шийдвэр.

2.6.Даатгуулагч нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ журмын 2.2-т заасан өөрт холбогдох баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд тухайн даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох тухайн жилийн нэрийн дансны эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүнгийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тодорхойлно.

2.7.Даатгуулагч тэтгэврийн төрлөөс хамааран энэ журмын 2.2, 2.3, 2.5-д заасан баримт бичгээс өөрт шаардлагатай баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

#### Гурав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

3.1.Цэргийн алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.1.1.энэ журмын 2.2-т заасан өөрт холбогдох баримт бичиг;

3.1.2.цэргийн албанд татагдсан, элссэн, албан тушаалд томилогдсон, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр цэргийн албанаас чөлөөлсөн тухай цэргийн анги, байгууллагын тушаал, шийдвэр, цэргийн алба хаасан хугацааны талаарх цэргийн байгууллагын архивын лавлагаа;

3.1.3.цэргийн батлах, хэрэв засвартай тохиолдолд цэргийн байгууллагын архивын лавлагаа;

3.1.4.цэргийн алба хаагчийн цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг сэргээн тогтоосон бол шүүхийн шийдвэр;

3.1.5.холбогдох хуулийн дагуу цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцох тохиолдолд тухайн цэргийн байгууллагын цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцсон тодорхойлолт;

3.1.6.цэргийн алба хаагчийн далд орон тоонд, эсхүл нууцалбал зохих албанд алба хаасан хугацааны лавлагаа, тэтгэвэр тогтоолгох цалин хөлсний тодорхойлолтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нөхцөлийн дагуу хүлээн авч, нууцыг хамгаалах нөхцөл, шаардлагыг хангасан нөхцөлд тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

3.2.Цэргийн алба хаагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.2.1.энэ журмын 3.1-д заасан баримт бичиг;

3.2.2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан нөхцөл, шалтгаанаар гарсан ослыг мөн

хуулийн 1 дүгээр зүйлд заасан байгууллагын дэргэдэх комиссоос судлан бүртгэж, тогтоосон, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн хянан баталгаажуулсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”.

3.3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

3.3.1.энэ журмын 3.1, 3.2.2-т заасан баримт бичиг;

3.3.2.хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо, ам бүлийн тодорхойлолт.

Дөрөв.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход  
бүрдүүлэх баримт бичиг

4.1.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25.1-д заасан үндэслэлийг баталгаажуулж, дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ:

4.1.1.тэтгэвэр тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ өөрчлөгдсөнийг нотлох баримт, архивын лавлагаа, тодорхойлолт;

4.1.2.тэтгэвэр тогтоолгоход баримталсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь өөрчлөгдөх үндэслэлтэйг нотлох баримт, архивын лавлагаа, тодорхойлолт;

4.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоонд өөрчлөлт орсон бол ам бүлийн тодорхойлолт.

4.2.Энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан 1995 оноос хойших хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын байгууллага тодорхойлно.

Тав.Тэтгэвэр олгох

5.1.Нийгмийн даатгалын байгууллага энэ журамд заасны дагуу даатгуулагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хугацаанд тэтгэвэр тогтоож, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу олгоно.

5.2.Тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний сонгосон арилжааны банкаар дамжуулан сар бүр олгох бөгөөд сонгосон арилжааны банкны нэр, дансны дугаарыг тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтаар авч нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

5.3.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 6 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас шалгаж, тэтгэврийг өөрчлөн тогтоож олгоно. Хэрэв Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 7.2, 7.3-т зааснаар нэмэгдүүлэх бол хүсэлтээ харьяалах нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.4.Тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарч Нийгмийн хамгааллын хэлэлцээргүй гадаад улсын иргэншил авсан бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24.2.3-т заасан хугацаанаас эхлэн тэтгэвэр олголтыг зогсооно.

5.5.Тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарч Нийгмийн хамгааллын хэлэлцээртэй улсын иргэншил авсан бол тухайн улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

5.6.Монгол Улсын тэтгэвэр авагч иргэн гадаад улсад удаан хугацаагаар амьдарч байгааг тухайн улсын нотлох баримтыг үндэслэн гаргасан Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолтыг үндэслэн олгоно.

#### Зургаа. Хариуцлага

6.1.Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдүүлэх зэргээр тэтгэврийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэврийг буруутай этгээдээр хуульд заасны дагуу бүрэн төлүүлж, тэтгэврийн даатгалын санг хохиролгүй болгох, буруутай этгээдэд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон бусад хууль тогтоомж, энэ журмыг зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан нийгмийн даатгалын байцаагч, ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 12 сарын 27-ны  
дугаарт бүртгэв.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ 6516**

2023 оны 12 дүгээр  
сарын 07-ны өдөр

Дугаар А/177 А/433

Улаанбаатар  
хот

**Журам, маягтын загвар  
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,  
Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг,  
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-  
ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар,  
"Эмнэлгийн хуудасны маягтын загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар  
/Л.Мөнхзул/, эрүүл мэндийн байгууллагад тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар  
(Б.Батжаргал), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар  
(А.Өнөржаргал)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 14 дугаар сарын 07-ны өдрийн А/177/14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ДААТГУУЛАГЧИД ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу даатгуулагч, хүнд эмнэлгийн хуудас олгох, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эмнэлгийн хуудас бичих, олгох, бүртгэх, хяналт тавих үйл ажиллагааг цаасан болон цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.3. Эмнэлгийн хуудас нь нэгдсэн дугаартай байх ба цахим эмнэлгийн хуудасны дугаарыг програмаас шууд олгоно.

1.4. Энэ журмын 2.1-т заасан эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох үндсэн баримт болно.

1.5. Эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагын болон улсын бүртгэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн сангийн бүртгэл, өвчний түүх, амбулаторийн карт, үзлэг, шинжилгээ, оношийн үндэслэл, явцын болон төгсгөлийн дүгнэлт, эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэр, үйлдвэрлэлийн ослын акт (зөвхөн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд)-ыг тус тус үндэслэн олгоно.

1.6. Эмнэлгийн хуудсыг бичиж, олгож байгаа эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, хяналт, шалгалт хийх эрх бүхий төрийн байгууллагын албан тушаалтан нь авилга, ашиг сонирхлоос ангид байж, эмнэлгийн мэргэжилтний болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

Хоёр. Эмнэлгийн хуудас бичих эрүүл мэндийн байгууллага

2.1. Даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн хуудас бичих эрхтэй дараах төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (цаашид "эрүүл мэндийн байгууллага" гэх) олгоно. Үүнд:

2.1.1. өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв;

2.1.2. амаржих газар;

2.1.3. нэгдсэн эмнэлэг;

2.1.4. тусгай эмнэлэг;

2.1.5. тусгай мэргэжлийн төв;

2.1.6. төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;

2.1.7.бүсийн оношилгоо эмчилгээний төв;

2.1.8.уламжлалт анагаах ухааны эмнэлэг;

2.1.9. сувиллын клиник тасаг.

2.2.Ердийн өвчин, ахуйн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөний улмаас энэхүү журмын 2.1-т заасан эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг дараах байдлаар бичиж олгоно. Үүнд:

2.2.1.ердийн өвчнөөр өвчилсөн, ахуйн осолд өртсөн, жирэмсний 28 долоо хоногоос дотогш хугацаанд амьдрах чадваргүй хүүхэд төрүүлсэн болон Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 66 өдөр хүртэл хугацаагаар;

2.2.2.мэргэжлээс шалтгаалсан өвчин, хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орсон, эрхтний донор болсон, үйлдвэрлэлийн осол болон хурц хордлогод өртсөн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг мэргэжлээс шалтгаалсан өвчний төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг эсхүл тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 132 өдөр хүртэл хугацаагаар;

2.2.3.гадаад оронд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн түүний байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан хугацаагаар;

2.2.4.албан томилолтоор ажиллах эсхүл ээлжийн амралт эдэлж байх хугацаандаа өвчилсөн даатгуулагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас амбулаториор ажлын 5 өдрөөс илүүгүй, хэвтэн эмчлүүлсэн болон өдрийн эмчилгээ хийлгэсэн бол тусламж үйлчилгээ үзүүлсэн хугацаагаар;

2.3.Жирэмсэн, амаржсан даатгуулагч эхэд жирэмсэн болон төрөлтийн үеийн эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас дараах байдлаар эмнэлгийн хуудас олгоно. Үүнд:

2.3.1.жирэмсэн, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээж төрүүлсэн эх, хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эх, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээсэн боловч Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн даатгуулагч эхэд эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас жирэмсний эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлсэн өдрөөс, амаржсаны эмнэлгийн хуудсыг тухайн эхийн амаржсан өдрөөс эхлэн тус бүр 60 хоног (ихэр бол нийт 140 хоног)-ийн хугацаагаар;

2.3.2.гадаад оронд байгаа жирэмсэн, амаржсан даатгуулагч эхэд жирэмсний болон төрөлтийн үеийн эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, эмнэлэг хяналтын комиссын хурлын



шийдвэрийг үндэслэн түүний байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.3.1-т заасан хугацаагаар;

2.3.3.төрөх хугацаанаас өмнө амаржсан даатгуулагчид жирэмсний эмнэлгийн хуудсыг хяналтад авсан эрүүл мэндийн байгууллага, амаржсаны эмнэлгийн хуудсыг тухайн даатгуулагчийн амаржсан эрүүл мэндийн байгууллагаас энэ журмын 2.3.1-т заасан хугацаагаар.

2.4 Даатгуулагч эхэд жирэмсний эмнэлгийн хуудас авсан эсэхээс үл хамааран амаржсаны эмнэлгийн хуудсыг олгоно.

#### Гурав. Эмнэлгийн хуудас олгох хугацаа

3.1.Амбулаториор эмчлүүлсэн даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг эмчлэгч эмчийн шийдвэрээр 14 хүртэл хоногоор, хэвтэн эмчлүүлсэн, өдрийн эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлсэн хоногоор тус тус олгоно.

3.2.Энэ журмын 2.2.1-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас авч байх хугацаандаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хорт хавдар, сүрьеэ анх оношлогдсон, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орсон, эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг ажлын 132 өдөр хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн олгож болно. Энэ тохиолдолд ердийн өвчин, ахуйн ослын шалтгаанаар эмнэлгийн хуудас бичүүлсэн хугацааг ажлын 132 өдрөөс хасаж тооцно.

3.3.Амбулаторийн тусламж, үйлчилгээг 14 хоногоос дээш хугацаагаар үргэлжлүүлэн үзүүлэх шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас олгох хугацааг Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрээр дараах байдлаар сунгана. Үүнд:

3.3.1.энэ журмын 2.2.1-д заасан эмнэлгийн хуудасны хугацааг 14 хүртэл хоногоор;

3.3.2.энэ журмын 2.2.2-т заасан эмнэлгийн хуудасны хугацааг 30 хүртэл хоногоор.

3.4.Эмнэлэг хяналтын комиссгүй алслагдсан сумын эрүүл мэндийн төв нь эмч нарын хамтарсан үзлэгийн шийдвэрээр эмнэлгийн хуудасны хугацааг сунгаж болно.

3.5.Эмчлэгч эмч болон эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтан нь даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг энэ журамд заасан хугацаанд багтаан бичиж, баталгаажуулан, хавсралт мэдээллийн хамт илгээнэ.

#### Дөрөв. Эмнэлгийн хуудас олгох

4.1.Даатгуулагч эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байх хугацаанд эмнэлгийн хуудас авах эсэх талаар эмчлэгч эмчид мэдэгдэнэ. Эмнэлгийн хуудсыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч дууссан болон жирэмсний амралт эхэлсэн эсхүл амаржсан өдрөөс хойш доорх хугацаанд багтаан цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бичнэ. Үүнд:

4.1.1.хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ авч дууссан өдрөөс хойш ажлын 10 өдөрт;

4.1.2.жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлсэн болон амаржсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногт;

4.1.3.энэ журмын 2.2.3, 2.3.2-т заасан даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч дууссан болон жирэмсний амралт эхэлсэн, амаржсан өдрөөс хойш хуанлийн 60 хоногт.

4.2.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд эмнэлгийн хуудас бичих хугацаа дууссан өдрөөс хойш хуанлийн 30 хоногт багтаан энэ журмын 1.5-д заасан болон хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримт бичиг, эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг тус тус үндэслэн олгоно.

4.3.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага “Цахим эмнэлгийн хуудасны программ”-ыг хамтран ашиглах гэрээ байгуулна. Гэрээнд “Цахим эмнэлгийн хуудасны программ” ашиглах эрх олгох, нууцлалын гэрээ байгуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох, хяналт тавих зэргийг тусгасан байна.

4.4.Цахим эмнэлгийн хуудас бичих эрхийг холбогдох программ хөгжүүлэгч байгууллагад нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно. Эрх олгохдоо эмнэлгийн хуудасны холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөж илгээж буй байдал, эмнэлгийн хуудсыг цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн эсэх зэрэг мэдээллийг шалгана.

4.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэдээллийн технологийн төв нь цахим эмнэлгийн хуудас олгосон жагсаалтын түүхчилсэн архив үүсгэн хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан ажиллана.

4.6.Программ хангамж, сүлжээ, техник тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл болон холбогдох бусад шалтгааны улмаас эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн хуудсыг энэхүү журамд заасан хугацаанд багтаан цахимаар илгээх боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар программ хөгжүүлэгч байгууллага цахим эмнэлгийн хуудасны програмд мэдээлэл оруулж шийдвэрлүүлнэ.

4.7.Программ хангамж, сүлжээ, техник тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл болон эмнэлгийн хуудас цахимаар бичиж олгох боломжгүй бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд эмнэлгийн хуудсыг цаасан хэлбэрээр дараах байдлаар бичнэ. Үүнд:

4.7.1.даатгуулагчийн болон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг хэвлэмэл хуудасны асуумжийн дагуу үнэн зөв, бүрэн бичиж, тэмдэглэх;

4.7.2.оношийг өвчний олон улсын ангиллын кодоор бичих;

4.7.3.эмнэлгийн хуудсыг засваргүй, гаргацтай бичих.

4.8.Эрүүл мэндийн байгууллагын дарга, ерөнхий эмч (захирал, эрхлэгч) эмнэлгийн хуудасны үндэслэлийг шалгаж баталгаажуулна.

4.9. Эрүүл мэндийн байгууллага "Эмнэлгийн хуудас олгосон тухай бүртгэл" хөтлөн харьяа нийгмийн даатгалын байгууллагад сар бүр цахим хэлбэрээр илгээнэ.

4.10. Эмнэлгийн хуудасны мэдээллийг алдаатай, дутуу бичсэн, засварласан, үрэгдүүлсэн бол хүчингүйд тооцно. Уг эмнэлгийн хуудасны дагуу тэтгэмж олгоогүй тухай ажил олгогчийн тодорхойлолтыг үндэслэн эмнэлгийн хуудас анх бичсэн эрүүл мэндийн байгууллага өмнөх эмнэлгийн хуудас бичигдсэн өдрөөс хойш 28 хоногийн дотор дахин олгоно. Нийгмийн даатгалын байгууллага хүчингүйд тооцсон эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгосон эсэхийг цахим мэдээллийн сангийн бүртгэлд тулгуурлан хянана.

4.11. Дараах тохиолдолд эмнэлгийн хуудас олгохгүй. Үүнд:

4.11.1. даатгуулагч тухайн эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ аваагүй;

4.11.2. даатгуулагч хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас тусгаарлагдсан, гоо сайхны мэс засал хийлгэсэн, рашаан сувилалд сувилуулсан;

4.11.3. хүүхэд үрчилж авсан болон тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болсон;

4.11.4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч буй даатгуулагчид тухайн тэтгэвэр тогтоолгосон өвчний оношоор.

4.12. Эмнэлгийн хуудсыг тусламж үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас илүү хоногоор бичиж олгохгүй бөгөөд энэ журмын 4.13-т зааснаас бусад тохиолдолд урьдчилан бичиж олгохгүй.

4.13. Даатгуулагчид үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний дуусах хугацаа амралтын өдөр эсхүл нийтээр амрах баяр ёслолын өдөр таарсан тохиолдолд эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ дуусах хугацааны өмнөх сүүлийн ажлын өдөр бичиж олгож болно.

4.14. Эрүүл мэндийн байгууллага нь магадлагч эмчээс буцаасан эмнэлгийн хуудсыг энэ журмын 4.2-т заасан хугацаанд багтаан дахин илгээнэ.

4.15. Эмнэлгийн хуудас олгох, хяналт тавихдаа улсын бүртгэл, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сан зэрэгт үндэслэнэ.

4.16. Хэвтэн эмчлүүлсэн болон өдрийн эмчилгээ хийлгэсэн тохиолдолд өвчний түүхийн, амаржсан тохиолдолд төрөлтийн түүхийн дугаарыг "Цахим эмнэлгийн хуудасны програм"-д тус тус бүртгэнэ.

4.17. Хүндэтгэн үзэх шалтгааныг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2.1.5-д зааснаар ойлгоно.

Тав. Хяналт тавих

5.1.Эмнэлгийн хуудасны бичилт, олголттой холбоотой маргааныг эрүүл мэндийн байгууллага, тэтгэмж олголттой холбоотой маргааныг нийгмийн даатгалын байгууллага тус тус хянан шийдвэрлэнэ.

5.2.Нийгмийн даатгалын байгууллага эмнэлгийн хуудас бичих олгохтой холбоотой асуудлаар даатгуулагч, хүн, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

5.3.Эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл, цахим бүртгэл хөтлөлтөд улирал тутамд дотоодын хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллана.

5.4.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч эмнэлгийн хуудасны бичилт, олголтод тавих хяналт шалгалтын хуваарийг нийгмийн даатгалын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, тайланг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

5.5.Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл нь энэ журмын 5.4-т заасан тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийж, саналыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.6.Төв болон орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч эмнэлгийн хуудасны бичилт олголтын үндэслэлд цахим хяналт хийхдээ тэтгэмжийн програмын цахим мэдээллийн сангийн бүртгэлээс дараах шалгуураар түүвэрлэн шалгана. Үүнд:

5.6.1.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нэг жилд 3-аас дээш удаа авсан;

5.6.2.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 30 хоногоос дээш хугацаагаар авсан;

5.6.3.тэтгэмж олгосон хугацаа давхацсан;

5.6.4.нэг өдөр ижил мөнгөн дүнгээр 2 ба түүнээс дээш удаа тэтгэмж авсан.

5.7.Орон нутгийн өвчлөлийн байдал, төрөлтийн тоо, хүн амын хөдөлгөөн, тэтгэмж авсан даатгуулагчийн тооны өсөлт, бууралт зэрэг нөхцөл байдалтай уялдуулан бусад шалгуур үзүүлэлтийг боловсруулан хяналт шалгалт хийж болно.

#### Зургаа. Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ

....oOo....



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
 Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын  
 07-ны өдрийн 100 дугаар тушаалын  
 хоёрдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ХУУДАС №



QR код:  
 Регистрийн дугаар /  
 Дахин давтагдашгүй дугаар/

/эх/-ийн нэр

1. Ургийн овог:.....Эцэг  
 .....Нэр.....
3. Оршин суугаа хаяг:.....аймаг, /нийслэл/.....сум/дүүрэг/.....  
 .....баг/хороо/.....
4. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:.....

5. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан: /доогуур нь зурах/  
 1. Ердийн өвчин  
 2. Ахуйн осол  
 3. Мэргэжлээс шалтгаалах өвчин  
 4. Үйлдвэрлэлийн осол

6. Тохирохыг сонгох / доогуур нь зурах/  
 1. Жирэмсний  
 2. Амаржсаны

7. Оношийн шифр /Өвчний олон улсын ангилал-ICD/.....

8. Эмчлүүлсэн/ Чөлөө олгосон/ хугацаа:  
 Эхэлсэн.....он.....сар.....өдөр Дууссан.....он.....сар.....өдөр
9. Эмчлүүлсэн/ Чөлөө олгосон/ хоног:.....  
 1. Амбулатороор: ..... 2. Хэвтэн эмчлүүлсэн: .....
10. Эмнэлгийн хуудас олгосон эмнэлгийн нэр.....

Ерөнхий эмч / Эмчийн код/ .....  
 ..... /  
 /  
 ( гарын үсэг) (нэр)  
 Баталгаажуулалт

Эмчлэгч эмч /Эмчийн код/.....  
 ..... /  
 /  
 (гарын үсэг) (нэр)  
 Эмнэлгийн хуудас бичсэн  
 20...он...сар...өдөр

11. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт:  
 Эмнэлгийн хуудас хүлээн авсан:  
 20 ..он..сар.. өдөр  
 Хянасан:  
 20 ..он..сар.. өдөр  
 Тэтгэмж авах эрх үүссэн эсэх: 1.Тийм 2.Үгүй

.....аймаг.(дүүрэг)-  
 ийн Нийгмийн  
 даатгалын газрын магадлагч  
 эмч ...../  
 /  
 (гарын үсэг) (нэр)

### ТЭТГЭМЖИЙН ТООЦОО

	Сар	Ажлын хоног	Тэтгэмж бодох хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого	Нэг сарын дундаж хөдөлмөрийн хөлс түүнтэй адилаах орлого	Нэг өдрийн дундаж хөдөлмөрийн хөлс түүнтэй адилаах орлого	Тэтгэмж бодох хувь	Нэг өдөрт ногдох тэтгэмж ийн хэмжээ (3*4)	Тэтгэмж олгох хоног			Олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
								Бүгд (7+8)	Ажил олгогчо ос	Нийг мийн даатг алын санга ас	Бүгд (10+11)	Ажил олгог чоос (5x7)	Нийгмийн даатгалын сангаас(5 x 8)
	А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	...-р сар												
2	...-р сар												
3	...-р сар												
4	...-р сар												
5	...-р сар												
6	...-р сар												
7	...-р сар												
8	...-р сар												
9	...-р сар												
10	...-р сар												
11	...-р сар												
12	...-р сар												
13	Дүн												

Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа..... жил.....сарыг тодорхойлсон:

Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтан: ..... / ..... /  
( гарын үсэг) ( нэр)

Аж ахуйн нэгж, байгууллагын: Дарга ..... / ..... / ( гарын үсэг) ( нэр)  Баталгаажуулалт:  Нягтлан бодогч ..... / ..... / (гарын үсэг) (нэр) 20...оны ...сарын... өдөр	Нийгмийн даатгалын байгууллагын: байцаагч (ажилтан)..... / ..... / ( гарын үсэг) ( нэр)  Баталгаажуулалт:  Хянасан байцаагч: ..... / ..... / (гарын үсэг) (нэр) 20...оны ...сарын...өдөр
--	--

# ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ

## ЭМНЭЛГИЙН ХУУДАС №



1.

QR код:  
Регистрийн дугаар  
Дахин давтагдашгүй дугаар

2. Ургийн овог:..... Эцэг /эх/-ийн нэр ..... Нэр.....
3. Оршин суугаа хаяг:..... аймаг, /нийслэл/..... сум/дүүрэг/.....  
..... баг/хороо/.....
4. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:.....
5. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан:  
1. Ердийн өвчин  
2. Ахуйн осол  
3. Мэргэжлээс шалтгаалах өвчин  
4. Үйлдвэрлэлийн осол
6. Оношийн шифр /Өвчний олон улсын ангилал-ICD/.....
7. Хугацаа:  
Эхэлсэн..... он..... сар..... өдөр  
Дууссан..... он..... сар..... өдөр
8. Эмчлүүлсэн хоног:.....  
1. Амбулатороор:.....  
2. Хэвтэн эмчлүүлсэн:.....
9. Эмнэлгийн хуудас олгосон эмнэлгийн нэр.....

Ерөнхий эмч / Эмчийн код/..... /  
( гарын үсэг) ( нэр)

Баталгаажуулалт

Эмчлэгч эмч /Эмчийн код/..... /  
( гарын үсэг) ( нэр)

Эмнэлгийн хуудас бичсэн 20...он...сар...өдөр

10. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт:  
Эмнэлгийн хуудас хүлээн авсан: 20...он...сар...өдөр  
Хянасан: 20...он...сар...өдөр  
Тэтгэмж авах эрх үүссэн эсэх: 1.Тийм 2.Үгүй

..... аймаг,(дүүрэг)-ийн Нийгмийн  
даатгалын газрын магадлагч эмч..... /  
( гарын үсэг) ( нэр)

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖИЙН ТООЦОО

Сар	МД	Хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх бүтэн ажилласан 3 сарын				Тэтгэмж бодох	Нэг өдөрт ногдох тэтгэмж (3x4) /төгрөгөөр/	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хоног			Олговол зохих тэтгэмж (төгрөгөөр)		
		Хөдөлмөрийн түүнтэй адилтгах аялал	Ажлын хэсэг	Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөдөлс.	Хувь			Бүгд (7+8)	Ажил олгогчоос	Нийгмийн даатгалын сангаас	Бүгд (5x6)	Ажил олгогчоос (5x7)	Нийгмийн даатгалын сангаас(5 x 6)
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
...-р сар	1												
...-р сар	2			x	x	x	x	x	x	x	x	x	
...-р сар	3												
Дүн (1+2+3)	4												
Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хянасан дүн	5												

Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа..... жил..... сарыг тодорхойлсон:

Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтан:..... / .....

Аж ахуйн нэгж, байгууллагын:      Нийгмийн даатгалын байгууллагын:

Дарга...../ ...../ байцаагч (ажилтан)...../ ...../ ( гарын үсэг) (нэр)

Баталгаажуулалт:      Баталгаажуулалт:

Нягтлан бодогч...../ ...../ Хянасан байцаагч:...../ ...../ (гарын үсэг) (нэр)      (гарын үсэг) (нэр)

20...оны...сарын...өдөр

20...оны...сарын...өдөр





Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 12 сарын 28-ны  
өдрийн 6579 дугаарт бүртгэв.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.13.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.7, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


Нэг. "Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам"-ыг шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, програм хангамжийг даалгаврын дагуу боловсруулж 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны "Журам батлах тухай" А/132 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Батсүх)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНЦЭЦЭГ



НДЕГ Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох,  
хэрэглэх журам ЖРМ-БХСГ-2023



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ  
ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-БХСГ -2023

Баталсан:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ГАНЦЭЦЭГ

Боловсруулсан:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

С.ЛХАГВАДОРЖ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



## АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нэр томъёоны тодорхойлолт
6. Тэтгэвэр тогтоох дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хянах, хэрэглэх
7. Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоох
8. Тэтгэвэр тогтоосон дундаж цалинг өөрчлөх
9. Хяналт, хариуцлага

НДЕГ Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам ЖРМ-БХСГ-2023

Нийгмийн даатгалын ерөнхий ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 419 дугаар тушаалын хавсралт

## ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх, 1995 оноос өмнөх үеийн цалин хөлс нь архивын, эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, итгэлцүүр хэрэглэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалаар баталсан 1995 оноос өмнөх хугацааны ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэх, тэтгэвэр тогтоох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт шалгалтын газар, Мэдээллийн технологийн төв, аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газар, тасаг, сумын байцаагч, архивын байгууллага, ажил олгогч, даатгуулагч, иргэн, тэтгэвэр авагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Нэр томъёоны тодорхойлолт

5.1. "Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого" /цаашид "цалин хөлс" гэх/ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д заасныг хэлнэ.

5.2. "Итгэлцүүр" гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасныг хэлнэ.

5.3. "Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин" гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан цалингийн хэмжээг ойлгоно.



НДЕГ Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам ЖРМ-БХСГ-2023

5.4. "Ажил, мэргэжил" гэж тэтгэвэр авагч, даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт бичигдсэн ажил, албан тушаалыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт "YAMAT"-08"-ыг баримтлан тодорхойлсныг хэлнэ.

#### ЗУРГАА. Тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг тодорхойлох, хянах

6.1. Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.4, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шимтгэл төлсөн цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд шимтгэл төлсөн сарын тоонд хуваах замаар тодорхойлно.

*Санамж<sup>1</sup>. Даатгуулагч (иргэн) 5-аас доош жил шимтгэл төлсөн байх нөхцөлөөр хөдөлмөрийн чадвараа алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн боловч уг даатгуулагч нь нийтдээ 60 сараас дээш шимтгэл төлсөн бол 60 сарын цалин хөлсний нийлбэрийг 60 сард хуваах замаар сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно.*

6.2. Даатгуулагч (иргэн) 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүссэн тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх өөрт нь ашигтай дараалсан 5 жилийн цалин хөлсний талаар зөвлөж уг хугацаанд авч байсан цалин хөлсний тодорхойлолтыг маягт (Б-НД-5)-аар ажил олгогчийн санхүүгийн баримтыг үндэслэн гаргуулан авна.

*Санамж<sup>2</sup>. Энэ тохиолдолд ажил олгогч нь татан буугдсан зэрэг шалтгаанаар тодорхойлох боломжгүй бол архивын лавлагаа гаргуулан авна.*

*Санамж<sup>3</sup>. Нийгмийн даатгалын улсын байцаагч нь даатгуулагч, ажилтны цалин хөлсний тодорхойлолт, архивын лавлагааны үндэслэлийг аж, ахуйн нэгж байгууллагын санхүүгийн баримтад болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Архивын ерөнхий газрын хооронд байгуулсан 2023 оны ХАГ/2023-07, НД-74/23 дугаар "Хамтран ажиллах гэрээ"-нд заасны дагуу архивын баримтад тулгуурлан шалгаж болно.*

6.3. Энэ журмын 6.2-т заасан даатгуулагч (иргэн)-ийн 1995 оноос өмнөх цалин хөлс нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд энэ журмын 7.1-д заасны дагуу жишиг цалинг баримтална.

*Санамж<sup>4</sup>. 2024 оноос эхлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар тушаалаар баталсан "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин"-д заасан холбогдох ажил мэргэжил, албан тушаалд харгалзсан жишиг цалинг баримтална.*



6.4. Даатгуулагч (иргэн) нь 1995 оноос хойш ажилласан хугацаанд шимтгэл төлсөн цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх өөрт нь ашигтай дараалсан 5 жилийн цалин хөлсний талаар зөвлөж тухайн хугацааны шимтгэл төлсөн цалин хөлсийг сонгож болно.

*Санамж<sup>5</sup>. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, 7.4.1, 7.4.2, 7.4.4-7.4.9, 7.5.2-т заасан даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч, улсын төсөв эсхүл нийгмийн даатгалын сангаас төлөгдсөн хугацаанд шимтгэл тооцон төлсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсөнд оруулан тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд уг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулж болно.*

*Санамж<sup>6</sup>. Ажил олгогч нь ажилтныхаа цалин хөлс, ээлжийн амралтын олговор зэрэг хоёр ба түүнээс дээш сарын цалин хөлсийг нэгтгэн нэг сард тайлагнасан нь тухайн үед мөрдсөн даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээнээс давсны улмаас уг цалин хөлсийг зөвхөн нэг сард тооцох нөхцөл үүссэн тохиолдолд ажил олгогчийн хүсэлт, залруулгын тайлан, цалин хөлсний санхүүгийн баримтыг үндэслэн нэгтгэн тайлагнасан цалин хөлсийг холбогдох саруудад нь залруулан, үүссэн шимтгэлийн зөрүүг нөхөн төлүүлснээр дундаж цалин хөлсийг тодорхойлж болно.*

6.5. Даатгуулагч (иргэн) нь үндсэн ажлын цагаасаа бусад цагт Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хэд хэдэн ажил давхар эрхэлж авсан цалин хөлсийг дундаж цалин хөлсөнд оруулах тохиолдолд "Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлогод шимтгэл ногдуулах хуудас"-ыг эсхүл нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг хавсаргана.

6.6. Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох 5 жилийн буюу 60 сарын хугацаанд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацаа орохоор бол уг хугацааны сар бүрийн цалин хөлсийг 420.0 мян.төгрөгөөр тооцож тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлно.

6.7. Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох 5 жилийн буюу 60 сарын хугацаанд Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацаа орохоор бол уг хугацааны хөдөлмөрийн хөлсийг тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлно.

6.8. Ажил олгогч нь шимтгэл төлөлтийн тайланд "даатгуулагчийн төрлийн код"-ыг буруу тайлагнасан нь тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийн хэмжээнд өөрчлөлт орохооргүй бол тухайн даатгуулагчийн төрлийг залруулахгүй.

*Санамж<sup>7</sup>. Үндсэн ажлын цагаасаа бусад цагт Хөдөлмөрийн тухай хуулийн 57 зүйлд заасан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу хэд хэдэн ажил давхар эрхэлсэн эсхүл тэтгэвэр тогтоолгосны дараа ажил хөдөлмөр эрхэлсэн зэрэг*



НДЕГ Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох,  
хэрэглэх журам ЖРМ-БХСГ-2023

даатгуулагчийн тухайн сарын цалин хөлсний хэмжээ нь өөрчлөгдөхгүй тохиолдолд уг цалин хөлсийг бүртгэсэн "даатгуулагчийн төрлийн код"-ыг өөрчлөхийг шаардахгүй байж болно.

6.9.Тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлоходоо Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

Санамж<sup>8</sup>.Тэтгэвэр бодох сар бүрийн цалинд шинэ итгэлцүүр хэрэглэхдээ сарын цалингийн дээд хэмжээг Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасныг баримтална.

Санамж<sup>9</sup>. Даатгуулагчийн энэ журмын 6.6-д заасны дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацааны хөдөлмөрийн хөлс (420.000 төг)-нд Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэхгүй.

Санамж<sup>10</sup>. Даатгуулагчийн энэ журмын 6.7-д заасны дагуу шимтгэл нөхөн төлсөн хугацааны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

#### ДОЛОО.Үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин хэрэглэх

7.1.Дараах тохиолдолд үндэсний ажил мэргэжлийн жишиг цалин /цаашид "жишиг цалин" гэх/-г үндэслэн даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно:

7.1.1.Энэ журмын 6.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон иргэний сонгосон нийт онуудын эсхүл зарим саруудын 1995 оноос өмнөх цалин хөлсийг тодорхойлох баримт нь архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байснаас шалтгаалан сарын дундаж цалин хөлсийг тодорхойлохгүйгээр тэтгэврийг нь тэтгэврийн доод хэмжээгээр тогтоосон бол тэтгэвэр авагчийн хүсэлтийн дагуу жишиг цалинг баримтлан тэтгэврийг нь өөрчлөн тогтоож болно;

7.1.2.Даатгуулагч 1995 оноос өмнө авч байсан цалин хөлсөө сонгон шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан боловч тухайн сонгосон онуудын нийт эсхүл зарим саруудын цалин хөлсний хэмжээ нь архивын баримтаар нотлогдохгүй, архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байгаа бол тухайн саруудын цалин хөлсийг жишиг цалингаар орлуулан тооцож болно.

7.2.Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1995 он хүртэлх хугацааны ажилласан жилээ нөхөн тооцуулсан тохиолдолд түүний тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг тодорхойлоход жишиг цалинг хэрэглэхгүй.

Санамж<sup>11</sup>.Даатгуулагч (иргэн) өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-1994 онд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан хугацаанд



НДЕГ Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох,  
хэрэглэх журам ЖРМ-БХСГ-2023

*ажилласан жил нь тасарсны улмаас уг хугацааг ажилласнаар нөхөн тооцуулсан бол энэхүү хугацааны дундаж цалин хөлсийг тооцоход жишиг цалинг хэрэглэ хгүй.*

7.3.Тэтгэврийг нь сарын дундаж цалин хөлсийг үндэслэн тогтоосон тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг жишиг цалинг хэрэглэн дахин өөрчлөн тогтоохгүй.

#### НАЙМ. Тэтгэвэр тогтоосон дундаж цалин хөлсийг өөрчлөх

8.1.Тэтгэвэр тогтооход баримталсан дундаж цалин хөлсийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд өөрчлөхгүй. Өөрөөр хэлбэл тэтгэвэр бодуулсан дундаж цалинг өөр онуудын цалингаар солихгүй.

8.2. Дараалсан зургаа, долоон жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг тэтгэвэр авагчийн хүсэлтэд үндэслэн нэг удаа өөрчлөн тогтооно. Энэ тохиолдолд тэтгэвэр авагч шимтгэл төлсөн сүүлийн 20 жил доторх дараалсан өөр 5 жилийн шимтгэл төлсөн цалинг сонгож болно.

8.3.Энэ журмын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтооходоо Засгийн газрын 2023 оны оны 238 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр"-ийг хэрэглэнэ.

#### ЕС. Хяналт, хариуцлага

9.1.Ажил олгогч нь ажилтан, иргэний энэ журмын 6.2-т заасан цалин хөлсний тодорхойлолтыг санхүүгийн баримтаас үнэн зөв гаргаж тодорхойлох үүрэг хүлээнэ.

9.2.Цалин хөлсний тодорхойлолт, бусад баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсний улмаас тэтгэврийг үндэслэлгүй эсхүл илүү тогтоолгон авсан бол буруутай этгээдээр тэтгэврийг нөхөн төлүүлж холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

9.4.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---





МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Зөвлөлийн газрын 11 багц Бага тойруу 44,  
Бүхбаатар дүүрэг Улаанбаатар хот, 14200  
Утас/Факс: (976-11) 32 14 33  
Цахим шуудан: info@nso.mn  
Цахим хуудас: www.nso.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
Х.БУЛГАНТУЯА ТАНАА

2023.12.25 № 01/1105  
Танон \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д малчин гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг; Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-т туслах малчин гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Иймд малчин болон туслах малчныг дээрх хуульд заасантай уялдуулан "Малчид гэдэг нь жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны үндсэн эх үүсвэр болгож байгаа 15 ба түүнээс дээш насны иргэд", "Туслах малчин гэж мал аж ахуйдаа туслуулахаар хөлсөөр ажиллуулж байгаа малчин" гэсэн тодорхойлолтыг мал тооллогод ашиглаж байна

Мал, тэжээвэр амьтдын тооллогын 2022 оны жилийн эцсийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны "Хур" системээр дамжуулан авах боломжтой бөгөөд уг асуудлаар тус хорооны Мэдээлэл технологийн газар (утас:51-267885, цахим хаяг: erdenemunkh@nso.mn)-тай холбогдоно уу.

Хүндэтгэсэн,

ДАРГА

Б.БАТДАВАА

142623402324